

НОМЫН ШҮҮМЖ
ТОЙМ

ЗӨВЛӨЛТИЙН МОНГОЛЧ
ЭРДЭМТДИЙН
ШИНЭ БҮТЭЭЛ

Монгольская Народная Республика. Справочник. Издательство «Наука». Главная редакция Восточной литературы. Москва. 1986. тираж 127000, 440 с.

ЗСБНХУ-ын ШУА-ийн хөдөлмөрийн гавьяаны одон тэмдэгт Дорно дахины судлалын институтээс 1986 онд хэвлэн гаргасан БНМАУ гэсэн лавлах нь Монгол, Зөвлөлтийн эрдэмтдийн хамтран зохиосон БНМАУ ын түүхийн нэгэн боть (нэмэн засварласан 3 дахь хэвлэл, Москва 1983) оос хойш манай улсын талаар туурвисан Зөвлөлтийн эрдэмтдийн шинэ бүтээлүүдийн нэг бөгөөд түүнд манай орны эртнээс эдүгээ хүртлэх байгаль газар зүй, хүн ам, хэл бичиг, шашин шүтлэгээс эхлээд эдийн засаг, соёл шинжлэх ухаан, урлаг, соёл, гадаад улс төр, эдийн засгийн харилцааг иж бүрэн багтаасан онцлогтой аж. Тус орны нийгэм эдийн засаг, соёлын өнөөгийн хэсэгт уг бүтээлийн гуравны хоёроос илүү хувийг эзлүүлэн маш дэлгэрэнгүй авч үзсэн нь манай улсын орчин үеийн хөгжилтэй Зөвлөлтийн болон гадаадын уншигчид танилцахад маш чухал хувь нэмэр оруулах бүтээл юм.

Лавлахын түүхэн найруулалын хэсгээс үзэхэд Монгол нутагт доод палеолитын үе буюу манай эриний өмнөх 30 мянга орчим жилийн тэр тээгээс хүн идээшиж Хүннү нарын овог аймгийн үед ирээд анхны хүй нэгдлийн байгуулалт нь задарч ангит нийгэмд шилжиж байжээ. Хүннү нарын үед дайн дажны хөлөөр боолчууд гарч ирсэн хэдий боловч нүүдлийн мал аж ахуй зонхилсон анхны хүй нэгдлийн байгуулалтын хүрээнд эцгийн эрхт ёсноос хальж боол эзэмшлийн нийгэмд орж чадаагүй байна. Монголын нийгмийн хөгжлийн ийм балар эртний үеэс социалист байгуулалтын өнөө үеийг хүртэл үе тус бүрийн онцлогийг уг лавлахын түүхэн найруулах гэсэн хэсэгт багтаажээ.

Өнөөгийн Монгол нутаг дээр оршиж байсан Түрэгийн хаант улсад Төв Азийн бусад нүүдэлчин ард түмнээс түрүүлж бичиг үсэг буй болсон, Киданы эзэнт улс соёл, шинжлэх ухаан хөгжүүлж түүнтэй Хятад, Солонгос, Тангад, Япон, Перс, Арабын Халифат зэрэг орнууд дипломат болон худалдааны харилцаатай байсан байхад XIII зууны эхээр Монголын тал нутагт ангийн өмнөх нийгмээс феодалын түрүү үед шилжих үйл явц бараг шувтарч Монголын феодалын нэгдсэн улс байгуулагдсан нь Монголын ард түмний түүхэнд бодит байдлаараа дэвшилт ач холбогдолтой байсан зэрэг түүхийн өөдрөг үзэгдлүүдийг лавлахад товч тодорхой тусгажээ.

Монголын феодалын нэгдсэн улс байгуулсан нь Чингис хааны нэртэй холбоотой бөгөөд тэрээр өөрийн үедээ цэргийн том удирдагч, төрийн болон улс төрийн том зүтгэлтэн, Монголын феодалын нэгдсэн улсыг байгуулж бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан нь эргэлзээгүй хэдий боловч түүний цаашдын үйл ажиллагаа, түрэмгий дайн нь байлдан дагуулсан ард түмнийхээ нийгэм-эдийн засгийн хөгжлийг хэдэн зуун жилээр ухрааж асар их хор уршиг учруулсныг иш баримттай дүгнэжээ. Чингисийн аян дайн Монголын ард түмнийг ч үгүйрэл ядууралд учруулж Монголын нийгмийн эдийн засаг, соёлын хөгжилтийг удаан хугацаагаар саатуулан барьсныг нэгэн адил дурджээ.

1271—1368 онд тогтсон Юан гүрний үед Хубилай хааны засаг төр цэргийн хүчинд дулдуйдаж булаан эзлэх дайныг үргэлжлүүлж байсан

нь эцсийн бүлэгт Хятад, Монголын аль алины нь үйлдвэрлэх хүчний өсөлт ба ард түмний аж байдалд сайнаар нөлөөлсөнгүй. Иймд байдал ч Юан гүрнийг мөхөлд хүргэсэн бөгөөд харин түүгээр эхэлсэн Монголын феодалын задралын үед (XIV зууны сүүлчээс XVII зууны сүүлч хүртэл) өвөрмөц зарим онцлогтой Монголын феодализмын түр зуурын цэцэглэлтийн үе байсан гэж шинэ бүтээлд дурдаад тэдгээр онцлог нь тухайн болон дараах үед Монголд хөдөлмөрийн нийгмийн хуваар гараагүй, хөдөө аж ахуйгаас гар үйлдвэр тасраагүй, худалдаа гар үйлдвэрийн төв нь хотууд болж чадаагүй, дотоодын нэгдсэн зах зээл бүрдээгүйд оршино гэжээ. Үйлдвэрлэх хүчний хөгжил хөдөлмөрийн хоёрдох том хуваарын түрүүчид буюу хөдөө аж ахуйгаас гар үйлдвэр салахад тулж очсон боловч давж алхсангүй. Тийнхүү хөгжингүй феодализмын үед нийтлэг байдаг зарим үйл явц Монголд гүйцэд явагдалгүй үлдсэн ба бусад ор нуудаас ялгаатайн тухай хийсэн дүгнэлт нь уг ойлголтыг нэлээд тодруулсан нь ажиглагдаж байна.

1488 онд Батмөнх даян-хан Монголын нэгдлийг дахин сэргээж Хятад, Төвд зэрэг орнуудтай дипломат болон худалдааны харилцаагаа зохицуулсан боловч 1500 оноос Хятадтай гэнэт харилцаа муудсаны шалтгаан одоо хүртэл тодорхойгүй бөгөөд энэ үеийн монголын дотоод амьдралын талаарч сурвалж бичигт гарах мэдээ сэлт бараг үгүйг зохиогчид тэмдэглэжээ.

Зохиолын «Манж Чин гүрний захиргааны үе дахь Монгол» гэсэн хэсэгт Хятадад болж буй хэрэг явдал тэнд Чин улсын бэхжиж буй байдал Оросын засгийн газрыг сэтгэл түгшүүлж Чин улсын хүчирхэг болоход дургүй байсан Орос улс Умард Монгол ба Зүүнгарын хаант улсыг Чингийн Хятад эзлэх явдлаа хэрэгжүүлэхэд нь бололцооны хирээр эсэргүүцэл үзүүлж байв гэсэн үнэмшилтэй дүгнэлт хийгээд гадаад улсуудтай харилцаа тогтоох гэсэн монголчуудын ямар ч оролдлогыг Манжийн эзэн хаад тас цохиж Монгол-Оросын худалдааг хаагаад, цэргийн харуулуудаараа оросоос монголыг зааглан хөндийрүүлж, төмөр хууль гэгчээрээ Монголд төмөр эдлэл, зэвсэг, дарь, шүү оруулахыг хориглож байсныг дурджээ.

Манжийн ноёрхолын үед Монголд олон зуун жилийн өмнөхийн нэгэн адил феодалын үйлдвэрлэлийн харьцаа ноёрхож, хамжилгын эрх, феодалын алба татвар байсаар иржээ. Монголын бүх хүн амын 8 хүрэхгүй хувийг эзлэх феодал ноёдууд бүх малын бараг хагас хувийг эзэмшиж байсны зэрэгцээ хятадын худалдаа мөнгө хүүлэгч капиталын дарлал, мөлжлөг туйлдаа хүрч байсныг тоо баримтаар харуулжээ.

Зохиолд Монголын ард түмний манжийн эсрэг тэмцлийг түүхчилэн харуулаад монголын ард түмний үндэсний чөлөөлөх хөдөлгөөний сэргэлтийн үр дүнд манжийн байлдан дагуулагчдын хоёр зуу гаруй жилийн ноёрхлыг 1911 онд устгаж тусгаар тогтносон монгол улсыг тунхаглаж Монголын төр ёсыг сэргээсний ач холбогдлыг заан тэмдэглэлээ.

XIII — XX зууны эхэн үеийн Монголын соёлын хэсэгт Монголын ард түмэн олон зуун жилийн турш өвөрмөц хэлбэртэй баялаг соёл бүтээж одон орон, тоо, анагаах ухааны зэрэг шинжлэх ухааны мэдлэгийн салбаруудыг хөгжүүлж ирснийг түүх дурсгал, түүхэн сурвалжид тулгуурлан тодорхой харуулжээ. Мөн хэсэгт Манжийн дарлалаас ангижирсан нь Монголын соёлыг хөгжүүлэх түлхэц өгсөн боловч богд гэгээний феодал засгийн бодит нөхцөлд соёлын үйл явц гүн гүнзгий, бүх нийтийг хамарсан шинж чанартай болж чадаагүй тухай дүгнэн тэмдэглэжээ.

БНМАУ-ын шинэхэн түүхийн хэсэгт зүй ёсоор ихээхэн байр эзлүүлжээ. Энэ хэсэгт шинэ залуу Зөвлөлт засаг болон Автономит Монголын харилцааны нэлээд ээдрээтэй асуудлыг хөндсөн байна. Тухайлбал Авто-

номит Монголын эрх баригчдаас Зөвлөлт засгийг дайсагнах хандлагаар хүлээн авч Зөвлөлт-Монголын хилийг хаасан, Зөвлөлт засгийн газрын дипломат төлөөлөгчийг хүлээн авахаас татгалзаж улмаар үндэсний эрх ашгаас урван тэрслэх замд шилжсэн зэрэг урьд өмнө харьцангуйгаар бага судлагдсан үйл явдлууд ч тусгалаа олжээ.

Чухам ингэж Октябрийн хувьсгалын нөлөөнөөс айсан Богдын засгийн газрын сэм хүлээснээр Хятадын милитаристууд Хүрээнд нэвтэрч улмаар Монголын автономийг устгасан байна. Ийм нөхцөлд Монголын жинхэнэ ард түмний төлөөлөгчид Зөвлөлт Оростой холбоо тогтоож дэлхийн хөдөлмөрчдийн их багш В. И. Ленин, Монголын ард түмний удирдагч чин зоригт Д. Сүхбаатар нарын үүсгэн байгуулсан Монгол-Зөвлөлтийн ард түмний ахан дүүгийн барилдалгааны үрээр Монголд 1921 оны ардын хувьсгал ялан мандсан билээ. Тэр цагаас хойш Монголын ард түмэн тусгаар тогтнолоо ЗСБНХУ-ын зүйл бүрийн тусламжийн үрээр батлан бэхжүүлж эдүгээ Аугаа их Октябрийн 70 жилийн ойтой золгож байна.

Энэ завсар Монголын ард түмний туулсан зам, олсон ололт амжилтыг БНМАУ гэсэн уг бүтээлд туйлын тодорхой харуулахын зэрэгцээ Монгол орны хөгжлийн онцлогыг яруу тод дүгнэжээ. Бүтээлд дурдахдаа хувьсгал нь үйлдвэрлэх хүчний хөгжилд саад болж байсан феодалын үйлдвэрлэлийн харьцааг устгах ёстой байв. Гэхдээ Монголд феодализмыг капитализмаар сольсонгүй. Тэргүүний орны пролетари нарын тусламжтайгаар сул хөгжилтэй орнууд түүхэн богино хугацаанд социалист байгуулалтын замд орж болох капиталист бус хөгжлийн тухай марксизм ленинизмын сургаал Монголын хувьсгалын зүг чигийг заагч од боллоо гэж уг бүтээлд заагаад 1921 оны хувьсгалын үе шат, өрнөлт, ялалтыг дэлгэрэнгүй тусгажээ.

Монгол-Зөвлөлтийн ард түмний бат зузаан найрамдал шинэ бүтээлийн бүлэг, зүйл бүрээс харагдах ба ялангуяа дэлхий дайны үед Монголын ард түмнээс ЗХУ-д 485 мянган адуу нийлүүлсний дотор 30 мянга гаруйг нь бэлэглэсэн, бэлгийн цувааг 8 удаа явуулж нийт 65 сая төгрөгийн үнэ бүхий бараа таваар, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг фронтод хүргэсэн зэрэг тоо баримттай танилцаж болно.

МАХН, БНМАУ-ын засгийн газар Зөвлөлтийн ард түмнийг бүх талаар дэмжин туслах ажлыг зохион байгуулахын зэрэгцээ Японы милитаристуудаас дорнод хилээ батлан хамгаалахад ихээхэн анхаарч имперелист Японы зэвсэгт хүчний ихээхэн хэсгийг саатуулан барьж байснаараа холбоотон гүрнүүдэд тусалсаныг шинэ бүтээлд цохон дурдаад Зөвлөлт-Монголын цэрэг өвөр монгол болон зүүн-хойд Хятадыг Японы булаан эзлэгчдээс чөлөөлж Японы Зэвсэгт хүчний гол бүлэглэл болох квантуны армийг хиар цохисон ялалт, дайчин нөхөрлөлийг иш татжээ.

БНМАУ-ын эдийн засгийн хөгжил, удаа дараагийн таван жилийн төлөвлөгөөнүүдийн биелэлтийг тодорхой тоо баримтаар тусгаад ялангуяа МАХН-ын XVIII их хурлаар баталсан улс ардын аж ахуйг 1981 — 1985 онд хөгжүүлэх 7-р таван жилийн төлөвлөгөө нь тус оронд социализмын материал-техникийн баазыг байгуулж дуусгахад шинэ чухал үе шат болсныг заан тэмдэглэжээ. Лавлахын түүхийн хэсгийн төгсгөлд өгүүлэхдээ намаас дэвшүүлсэн программын зорилтыг хэрэгжүүлэх нь эцсийн дүнд улс орныг хөгжингүй социалист нийгмийн түүхэн зурваст аажмаар шилжих зайлшгүй нөхцлийг хангахад хүргэнэ гэж дүгнэжээ.

Манай улсын нийгэм эдийн засгийн хөгжилтийг нэн эртнээс өнөө үеийг хүртэл багтаасан энэхүү номын бүх бүлэг, зүйлийг хамруулан нэгэн бяцхан тэмдэглэлд багтаах боломжгүй бөгөөд зөвхөн түүхийн хэсгийг нь уншаад төрсөн сэтгэгдэл ийм байна.

Монгол судлаач нэрт эрдэмтэд Л. М. Гатауллина, С. Д. Дылыков, И. С. Казакевич, С. К. Роцин, Г. С. Матвеева (хариуцлагатай редактор) нар эрхэлж олон тооны монгол судлаачид оролцон бүтээсэн энэхүү лавлах нь баялаг агуулга ба хэмжээний хувьд тус улсын талаар урьд өмнө хэвлэгдэн гарсан аль ч лавлахаас илүү чамбай, ялангуяа улс орны амьдралын бүхий л талыг багтаасан учир ямарч мэргэжлийн хүн ашиглаж болох шинжилгээ судалгааны болон практик ач холбогдолтой төдийгүй манай улсын талаар сонирхох гадаадын уншигчид, монгол судлаачдад гарын авлага болох үнэт шинэ бүтээл болсон нь дамжиггүй.

Э. Пунцаг

«ЭРГЭЖ ИРЭХГҮЙ НОМОНХАН НОМЫН ТУХАЙ

К. ИШИДА, «Кайразару Номонхан»
(Токио, 1985, х. 253)

К. Ишида*-гийн бичсэн «Эргэж ирэхгүй Номонхан» хэмээх номыг 1985 оны 9-р сарын 15-нд Японд хэвлэн гаргажээ. Энэхүү 18 бүлэг, 93 зүйл, 3 хавсралт, 253 талтай номыг Халх голын районд Японы милитаристуудыг бутцохисны 45 жилийн ойн босгон дээр гаргасан нь тохиолдлын бус зүйл гэдэг нь ойлгомжтой. Уг номонд олон төрлийн фото зураг, газрын зураг оруулж дурдатгал маягаар бичжээ.

Нэг талаас Халх голын районд болсон дайныг «хилийн будлиан», «орон нутгийн чанартай» дайн гэж үзэн түүхэн байдлыг гуйвуулж, нөгөө талаас Японы ард түмэнд уг дайныг Японы милитаристууд бус, харин монгол цэргүүд «хил зөрчин» өдөөн гаргасан мэтээр ойлгуулахыг оролдох, ингэснээрээ Японд милитарист үзэл санааг сэргээн дэвэргэх явдалд тойруу замаар дэмжлэг үзүүлэх утга агуулга бүхий ном зохиол Японд гарсаар байна. Ийм санаа Ишидагийн номд ч орхигдсонгүй.

Японы түүх бичлэгт Халх голын дайныг «Номонханы хэрэг явдал» гэж нэрлэдэг бөгөөд Халх голын эргийн ойролцоо, Хайлааст голоос хойш оршдог газрыг уг номонд «Хоёр толгойн дундах гурвалжин хэл бэрийн нам дор газар нь Номанхан болно» (86-р тал) гээд дайн үүсэх, шалтгааныг бичихдээ: «1939 оны 1-р сарын 17-нд гадаад Монголын хилийн цэргүүд Номонханы Манжийн талын хилийн харуулруу дайрснаар хэрэг явдал эхэлж (20-р тал), улмаар өдөөн хатгасан шинж чанартай болж өөрчлөгдсөн» гэжээ. Тэгвэл К. Яно тэргүүтэй групп Японы Квантуны армийн жанжин штабын даргын онцгой даалгавраар 1938 оны намар 2 сарын турш Дотоод Монголын хилийн районы ойролцоо (Халх голын сав газар. —) хийсэн шинжилгээ судалгааны гол зорилго нь: манай улсын хилийн район дахь цэргийн чухал газруудыг судлах, хилийн байдал болон харуул хамгаалалтыг нягтлан хил орчмын ард олны

*. Зохиогч нь 1902 онд төрсөн. Японы урлагийн дээд сургуулийн орос хэлний факультетэд суралцаж байгаад дараа нь ЗХУ-ын Москвагийн бүх холбоотын урлагийн академид судалгааны ажил хийв. 1936 онд «Мантэцу» (Манжуурын төмөр замын дэргэдэх судалгааны газар)-д ажилд оржээ. 1940 оны 9-р сард хил тогтоохоор хийсэн хэлэлцээрт нарийн бичгийн дарга, орчуулагчаар оролцсон. Дайны дараа Японы парламентын номын санд ажиллаж БНМАУ «Монгол-Орос-Япон хэлний дэлгэрэнгүй толь» «Чайковский» зэрэг ном бичжээ.